

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

/2025 оны жилийн эцсийн байдлаар/

Эрүүл мэндийн газар

2025.11.25

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв /сая/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилто т түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь	Үнэлгээ Хувь
				Он	Түвшин			
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ								
Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дулхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.								
Зорилт 2.2. Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ.								
1	2.2.1 Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ.		Хариу арга хэмжээний чадавх	2021			Томуу, томуу төст өвчний бэлэн байдлыг хангах чиглэлээр аймгийн онцгой комиссын шийдвэрээр батлагдсан 131 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2000 ширхэг түргэвчилсэн оношлуур, 7 төрлийн багаж тоног төхөөрөмж, Н95 амны хаалт 1000ш худалдан авч, салбаруудад хуваарилсан. Орон нутгийн 2025 оны төсөвт нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдол удирдлагын тогтолцоог дэмжих, томуу, томуу төст өвчний үеийн бэлэн байдлыг хангах зорилгоор 55 сая төгрөгийг суулгасан. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх тохиолдлын удирдлагын багийг Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 11 сарын 19-ний А/88 дугаар тушаалаар баталж, хариу арга хэмжээний үед шилжин ажиллаж байна. Томуу, томуу төст өвчний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн хурлыг 4 удаа хийж, 9 асуудал хэлэлцэж, 10 шийдвэр гарган, хэрэгжилтийг 95,6% ханган ажилласан. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг аймгийн засгийн даргын 2024 оны А/586 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулж, салбар дундын уялдаа холбоог хангаж, шийдвэр гарган, аймгийн онцгой комисст танилцуулан ажиллаж байна. Орхон аймаг дахь Улаанбурхан өвчний эрсдэлийн үнэлгээг Шуурхай удирдлагын багийн 9 гишүүний бүрэлдэхүүнтэй хийсэн. Гишүүдийн өгсөн магадлалын болон үр дагаврын асуумжид хариулсан онооны дунджаар 3,8 оноо буюу өндөр эрсдэлтэй, улбар шар түвшинд байна. Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/49 дугаар тушаалаар шуурхай удирдлагын 5 багийг 28	90

						<p>хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулж, багийн гишүүдийн үүрэгжүүлэн ажиллаж байна. Шуурхай удирдлагын багийн хурлыг 3, тандалт судалгаа, хариу арга хэмжээний багийн хурлыг 4 удаа хийж, бэлэн байдлыг хангах, сэжигтэй тохиолдлын хариу арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Улаанбурхан өвчний сэжигтэй 24 тохиолдол бүртгэгдэж 5 тохиолдол батлагдаж, хариу арга хэмжээг авч ажилласан.</p> <p>Орхон аймгийн Засаг даргын 2025 оны А/449 дүгээр захирамжийн дагуу “Хотын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх” ажлын хэсгийн хурлаар 110/141 оноогоор үнэлэгдэж 78%-ийн бэлэн байдлыг хангасан байна.</p>	
2	<p>2.2.2.хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.</p>		Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	2021		<p>2025 оны эхний хагас жилийн байдлаар 353751 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 123826 хийгдэж, нийт үзлэгийн 35 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1 хувиар өссөн. Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх үзлэгт 69343 нь хамрагдаж, үзлэгийн хамрагдалт 65,3%-тай байгаа бөгөөд улсын хэмжээнд 21 аймагтаа хамрагдалтаараа тэргүүлж байна. 0-17 насны 38072 хүүхэд буюу 100%, 18-с дээш насанд 31271 буюу 45,5 хувь үзлэгт бүрэн хамрагдсан. Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн 33 байгууллагын 3685 ажилтан албан хаагчдыг лавлагаа шатлалын эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан хамтран ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, дасгал хөдөлгөөнд идэвхтэй хийхийг уриалах, зөв зохистой хооллох, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл түгээхэд төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 27 удаагийн өдөрлөг, аян, форум, 316 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 20098 иргэнийг хамруулж, 24 төрлийн сурталчилгааны материалыг 6068 иргэнд түгээсэн. - Цахим хуудаст 789 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 1013184 хандалттай байна. - Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 33 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 5 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. 	100
3	<p>2.2.3.оношилгоо, эмчилгээний уламжлалт болон</p>	УТ 6.0 сая	Оношилгооны чадавх,	2021		<p>Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эхний хагас жилийн байдлаар тамхинаас гаргах чихний зүү эмчилгээ, парафин, шавар эмчилгээ, хүчилтөрөгчийн коктейль, бүтэн биеийн массажны сандал, битрон</p>	50

	орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэд оршин байгаа газар нутагтаа бүрэн оношлогдох, эмчлэгдэх боломжийг бүрдүүлнэ.		нэвтрүүлсэн шинэ технологи			гэрлийн аппаратыг нэмэгдүүлснээр тоног төхөөрөмжийн хангалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,6%-иар өссөн байна.	
4	2.2.4.яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг үндэсний түвшинд сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ.		Яаралтай тусламжийн чадавх	2021		<p>Орхон аймгийн Эрүүл мэндийн салбарын эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах 4 удаагийн сургалт “Орхон аймгийн Яаралтай тусламжийн өнөөгийн байдал”, “Амилуулах суурь тусламж”, “Лавшруулсан тусламж”, “Шокийн үеийн тусламж үйлчилгээ”, “Гэмтэгсдэд үзүүлэх тусламж үйлчилгээ”, “Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх журам” зэрэг 6 сэдвийн хүрээнд зохион байгуулж давхардсан тоогоор 1082 ажилтныг хамруулсан, 2 удаагийн ур чадварын тэмцээн зохион байгуулсан.</p> <p>1. Дэлхийн эмч нарын баярыг тохиолдуулан Эмч, эрүүл мэндийн байгууллагын ажилчдын дунд нотолгоонд суурилсан анагаах ухааны мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, бататгах, багаар ажиллах чадварыг хөгжүүлэх, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөж авьяасыг нээн илрүүлэх, сурталчлах зорилгоор “Doctors quiz night” арга хэмжээнд 22 ЭМБ-ын 168 эмч нарыг хамруулсан.</p> <p>2. Монгол улсын зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор, чиглүүлэгч багш Бямбаагийн Батбаяр агсны нэрэмжит амилуулах тусламжийн “Миний мэргэжил миний бахархал” ур чадварын тэмцээнийг Баян-Өндөр сумын ИТХ, ЗДТГ, Монголын яаралтай тусламжийн нийгэмлэг, Орхон Улаан загалмайн хороо, Орхон аймаг дэх Юнител ХХК-ын салбар, Эрдэнэдент шүдний эмнэлэг, Монос орхон салбаруудтай хамтран Залуучуудын ордонд зохион байгуулсан. Тэмцээнд оролцогчдыг Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй бүх байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн нэрсийг жагсаан "Random number generator" программ ашиглан санамсаргүй түүврийн аргаар сонгож нийт 18 байгууллагын 33 эмч эмнэлгийн мэргэжилтнийг 3 багт хуваарилж 3 үе шатаар тэмцээн явагдсан. Тэмцээний шүүгчээр МЯТН-ийн 3 сургагч багш ажиллаж нийлбэр дүнгээр 3-р байранд 76,7 оноогоор CPR ninja /БОЭТ, Анхны-Оч, Мэндцэцэн, Нийцэл, Учралтбаяр ӨЭМТ-үүдийн нэгдсэн/ баг, 2-р</p>	70

						<p>байранд 77,1 оноогоор Цохилт /ЭСЦ, Үйлсбадрах, Мөнхийнгэгээ, Энхжихмандариваа ӨЭМТ-үүд, Шүд холбооны нэгдсэн/ баг орсон ба Шилдэг багаар Avengers 81,4 оноогоор /Эрдэнэт медикал, Мөнхсүндрал ӨЭМТ, жаргалант СЭМТ, ХХЭМБ-уудын нэгдсэн/баг шалгарч 4,000,000 /4 сая төгрөгөөр шагнуулсан.</p> <p>Яаралтай тусламжийн багаж тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслийн хангалт 91%-д хүрсэн байна.Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чанар хүртээмж, багаж тоног төхөөрөмжийн хангалтад 1 удаа дэмжлэгт хяналт хийж зөвлөмж өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Үнэлгээгээр яаралтай тусламж үзүүлэх багийг томилж үүрэгжүүлэн, дуудлагын схем, зураглалыг баталсан байгууллага 80,5% байна.</p> <p>Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр:Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төгсөлтийн дараах сургалтад 2024-2025 оны хичээлийн жилд “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 6, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 1 эмнэлгийн мэргэжилтэн суралцаж байна. Хувийн хэвшлийн 7 ор бүхий клиник яаралтай тусламжийн мэргэшсэн сувилагчийг ажиллуулж байна.Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чадавх 91%-тай байна.</p>	
5	<p>2.2.5.Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг ханган, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна.</p>		Санхүүжилтийн үр ашиг	2021		<p>Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг үе шаттайгаар нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг хангах, мөн нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжих зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Уг шинэчлэлийн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн гүйцэтгэлд үндэслэн төсөв, төлбөр тооцоог хийх болсноор нөөцийн оновчтой хуваарилалт, санхүүгийн сахилга бат сайжирсан. -Үйлчилгээний чанар, хүртээмж, үр нөлөөнд суурилсан үнэлгээ, тайлагналын механизм бүрэлдэж, дотоод хяналт, гүйцэтгэлийн хариуцлага нэмэгдсэн. -Эрүүл мэндийн даатгалын хамрах хүрээ нэмэгдэж, төлбөрийн дарамт багассан нь иргэдийн тусламж үйлчилгээ авах хүртээмжид эерэгээр нөлөөлж байна. - Эмнэлгийн менежментийн уян хатан байдал сайжирсан: Бие даан шийдвэр гаргах эрх хэмжээ нэмэгдэж, байгууллагын дотоод бүтэц, нөөцийн зохион байгуулалт илүү үр дүнтэй болсон. -Гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийн үнэлгээний систем, кодчиллол, дата мэдээллийн чанарыг сайжруулан ажиллаж байна. 	50

6	2.2.6.эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ.	УТ 500.0 сая	Телемедицин нэвтрүүлсэн байгууллага	2021	-	3	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн 161 байгууллага интернэтийн сүлжээнд 100% холбогдсоноос 13 эрүүл мэндийн байгууллага Юнивишн, Мобинет ХХК-ийн dedicated 20mb хурдтай өндөр хурдны шилэн кабелийн интернэтийн сүлжээнд холбогдсон. Сум, өрх эрүүл мэндийн төвүүдэд 126 компьютер ашиглагдаж, ssd hard тавьж хурдыг сайжруулсан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн интернет хурдыг 100мб хурдтай байсныг 1гб болгон 10 дахин нэмсэн.Алсын зайн оношилгоо, телемедицинский техник тоног төхөөрөмж бүхий байгууллагын тоо 11, техник тоног төхөөрөмжийн хангалт 35 хувьтай байна. Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 11 өвчтөний мэдээллийг телемедицинээр дамжуулан оношилгоо, эмчилгээний зөвлөгөө авч ажилласан.Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түргэн тусламжийн 103 дуудлагын үйлчилгээний програм хангамжийг шинэчлэх ажлын хүрээнд 2025.02.14-нд сонгон шалгаруулалтаар Эгософт ХХК шалгарч ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. Ажлыг 2025.06.30-нд бүрэн дуусгаж хүлээн авна.	100
7	2.2.7.эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.		Эм, эмнэлгийн хэрэгслийн стандартын хэрэгжилт	2021			Аймгийн хэмжээнд нийтийн үйлчилгээтэй 74 эмийн сан, 8 эм ханган нийлүүлэх байгууллага иргэдэд үйлчлэн ажиллаж байгаагаас 2 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон, 1 эмийн санг 3 сарын хугацаатай түдгэлзүүлээд байна. -Эм ханган нийлүүлэх байгууллагуудаас эмийн сан бөөний үнээр эм авч иргэдэд борлуулдаг бөгөөд ЭХНБ-ын үнэ дээр дундажаар 15-25% нэмдэг бол иргэдэд жижиглэнгийн үнээр борлуулахдаа дундажаар 20-45% нэмж борлуулж байна. Эмийн хадгалалт, түгээлтэд тавих нийтлэг шаардлага MNS5530:2014 болон эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандартын дагуу эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн сангуудын стандартын хэрэгжилт дунджаар 95,25% байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 0,4% нэмэгдсэн байна. Үүнд: -“Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд 94,8%-тай үнэлгээтэй гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0,6%-аар сайжирсан байна.Эм ханган нийлүүлэх байгууллагын стандартын шаардлага 95,7%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0,2%-аар сайжирсан байна.	100
8	2.2.8.эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг		Арга хэмжээний хэрэгжилт	2021			Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 02/16 дугаар тогтоолоор Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 4 арга хэмжээтэй батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд эмч, сувилагч нарын дунд эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, шилдэг	100

сайжруулна.						<p>илтгэлүүдээр “Анагаах увидас” сэтгүүлийг 300 ширхэг хэвлүүлэн тараасан. Тайлант хугацаанд 22 эмч, эмнэлгийн мэргэжилтэн улсын төсвийн санхүүжилтээр төрөлжсөн болон мэргэжил дээлүүлэх сургалтад хамрагдсан. Ажлын байрны болон алсын зайн сургалтад 543 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан нь өмнөх үеийн мөн үеэс 0,2% өссөн үзүүлэлттэй байна. Магистр болон докторын сургалтад 14 эмч, эмнэлгийн мэргэжилтэн суралцаж байгаагаас 5 мэргэжилтэн нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр магистрын сургалтад шинээр элсэн суралцаж байна. Хүний нөөцийн бүрдүүлэлт 81%, хөтөлбөрийн хэрэгжилт 51%-тай байна.</p> <p>Үр бүтээлтэй ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг Эрүүл мэндийн яамны болон орон нутгийн шагналд тодорхойлж нийт 75 ажилтныг шагнаж урамшуулсан. Мөн эмч болон сувилагч нарын баяраар үр бүтээлтэй ажилласан 1 эмч, 1 сувилагчийг тус бүр 1,0 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. Эрүүл мэндийн байгууллагуудын тэмцээнд ажилттай оролцсон 2 мэргэжилтэнд тус бүр 150,0 мянган төгрөгийн мөнгөн шагналаар урамшуулсан.</p> <p>Бүсийн оношилгоо эмчилгээний төвд нийт 23 туслах сувилагчийг ажиллуулж байна. Үүнээс 10 сувилагчийн үйл ажиллагааны зардалд орон нутгийн төсвөөс 78,0 сая төгрөгийг шийдвэрлэн ажиллаж байна. 2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн нийт албан хаагчдын цалинг 8%-иар нэмэгдүүлж олгож эхэлсэн.</p>	
Хэрэгжилтийн дундаж хувь						84.2	

“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээ
ЭРҮҮЛ МЭНД							
1	Хүн амын дундаж наслалт	Жил	2019	70.2	74	73.66	70
2	Төрөлтийн нийлбэр коэффициент (нэг эмэгтэйд ногдох)	Тоо	2019	2.9	3.3	0.8	30
3	1000 амьд төрөлтөд ногдох	промилль	2019	13.3	10.3	10.2	100

	нялхсын эндэгдлийн түвшин						
4	1000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн харьцаа	промилль	2019	23.0	18.2	0.0	4.8
5	Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	хувь	2018	98.9	99	99.7	70
6	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	2019	77.4	87.0	51.9	59.6
7	10,000 хүн амд вируст гепатитын өвчлөл	тоо	-	3.4	2.5	0.3	100
8	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	2019	73.1	87.5	58.7	67.0
9	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	2019	30.0	70.0	47.0	21.9
10	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	хувь	2019	90.2	93.2	92.0	100
11	Тавт вакцины 3 дах тунгийн хамралтын хувь	хувь	2019	98.1	99.3	100.0	100
12	Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудын /УГУ/ эсрэг вакцины 2 дах тунгийн хамралтын хувь	хувь	2019	98.5	99.7	100.0	100
13	Иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээл, ядууралд өртөх эрсдэлийг бууруулсан нь	хувь	2020	0	50.0	30.0	60

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

АШЭМБАНТҮХМ А.ХОНГОРЗУЛ

ХЯНАСАН:

ХШҮМХАМ П.ХИШГЭЭ